МЭДЭЭ · 2024 оны 1-р сарын 10

ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ РУУ ИХ ХЭМЖЭЭНИЙ ХИМИЙН БОДИСТОЙ ХАЯГДАЛ УС НИЙЛҮҮЛЖ БАЙСАН ГАЗРУУДЫГ ШАЛГУУЛАХААР БОЛЛОО







Хан-Уул дүүргийн прокурорын газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх

ажлын хүрээнд Туул голын сав газрын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, хаягдал бохир ус гаргаж буй аж ахуйн нэгж байгууллагуудыг Ус, сувгийн удирдах газартай хамтран шалгаж, холбогдох арга хэмжээг авлаа.

Тодруулбал, тус дүүргийн нутаг дэвсгэрт арьс шир, ноос ноолуур боловсруулах чиглэлээр үйлдвэрлэл явуулдаг нэр бүхий 6 компанийн үйл ажиллагаатай танилцаж, Төв цэвэрлэх байгууламж руу нийлүүлж байгаа бохир уснаас нь дээж авч лабораториор шинжлүүлсэн байна.

Шинжилгээний дүнгээр 3 компанийн хаягдал бохир ус байгаль орчинд хохирол учруулах эрсдэлтэй, MNS ISO 6060:2001, MNS 5597:2006, MNS ISO 10523:2001, MNS ISO 11923:2001 стандартад зааснаас хэд дахин их химийн бодисын агууламжтай болох нь тогтоогджээ.

Тиймээс тухайн асуудлыг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлж, компанийн удирдлагуудад Усны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар прокурорын мэдэгдэл хүргүүлсэн байна.

> ***Зөрчлийн тухай хууль***
>
> ***6.2 дугаар зүйл.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль зөрчих***
>
> *3.Бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл урьдчилан цэвэрлээгүй бохир усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, үйл ажиллагааг зогсоож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.*

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1412